



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

Барилга буулгах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дэх заалт, 35 дугаар зүйлийн 35.1.11 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2011 оны 07-161/389, 2017 оны 22-07-112/47, 2022 оны 02-07-395/02 дугаар актуудаар ашиглалтын үйл ажиллагааг бүрэн зогсоож, шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон Сүхбаатар дүүргийн 17 дугаар хорооны Хороо, өрхийн эмнэлэг, цагдаагийн хэсгийн цогцолбор барилгыг буулгахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д зөвшөөрсүгэй.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Б.Батбямба)-д даалгасугай.

ДАРГА

Ж.БАТБАЯСГАЛАН

